



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 31 өдөр

Дугаар А/53

Бат-Өлзий сум

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, 32.1.4 дэх заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.1, 2.1.5 дахь заалт, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "2023 оны төсөв батлах тухай" 2022 оны 12 дугаар сарын 19-ны өдрийн 11/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Өвөрхангай аймгаас малчдад хямдралтай өвс, тэжээл татах тээврийн зардалд 1,500,000 (нэг сая таван зуун мянга) төгрөг, аймаг, сумын аварга малчдын шагналын өргөмжлөл тууз, медалийн зардалд 2,770,000 (хоёр сая долоон зуун далан мянга) төгрөг, нийт 4,270,000 (дөрвөн сая хоёр зуун далан мянга) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардалд шаардагдах 4,270,000 (дөрвөн сая хоёр зуун далан мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч (Ч.Батдулам)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН

Хөдөлгөөний үндэс

D:My Doc A-4 zahiramj/ZD/

622301113